



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/2/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	Error! Bookmark not defined.
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	Error! Bookmark not defined.
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	Error! Bookmark not defined.
2.8.3 Авлага.....	Error! Bookmark not defined.
2.8.4 Урьдчилгаа.....	Error! Bookmark not defined.
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	Error! Bookmark not defined.
2.8.6 Бараа материал	Error! Bookmark not defined.
2.8.7 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
2.8.8 Өр төлбөр.....	Error! Bookmark not defined.
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ


ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
21000, Дорнод аймаг, Хэрэн оум 7-р баг
З/ТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

БЯАНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.ХҮРЭЛЧУЛУУН ТАНАА

Ада, 03, 15 № 318

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяндун сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баяндун сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баяндун сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520250



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ





2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Х.Хүрэлчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баяндун сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж гүйцэтгэв.

Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/143 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баяндун сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Баяндун сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Баяндун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баяндун сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 2,870.2 сая төгрөгийн 2 хувь буюу 57,4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 3,441.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгайн сангийн, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн нь бүгд аудитад хамрагдсан.



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 5 байгууллага нь “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 18,725.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,725.3 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 5,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг зөрүүгүй нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн тухай хуульд төсвийг тухайн төсвийн захирагчид хамаарах хөтөлбөрийн дагуу төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхээр заасныг зөрчин сумын ЗДТГ-ын төсвөөс ИТХ-ын үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөн баталж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 80,289.4 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

Үүнд:

- *Баяндун сумын Засаг даргын тамгын газар:* Санхүүгийн тайланд 446.2 мянган төгрөгийн авлага дутуу тусгасан, санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд 52,504.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлыг /шүлхийд малаа устгуулсан иргэдийн нөхөн олговор/ тусгаагүйг тус тус залруулсан байна.
- *Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль:* ХХОАТ-ын 2,738.0 мянган төгрөгийн тооцоо үүсгэлгүй программын тохируулгаар хааж бичсэн, бараа материалын 373,3 мянган төгрөгийн гүйлгээний орлого, зардлын төрлийг зөрүүтэй тусгасныг санхүүгийн тайланд залруулсан байна.
- *Баяндун сумын Эрүүл мэндийн төв:* Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй олгосон 12,443.5 мянган төгрөгийн эмийг орлогод аваагүй байсныг санхүүгийн тайланд залруулсан байна.
- *Баяндун сумын Орон нутгийн хөгжлийн сан:* Олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл 9,225.3 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй байсныг санхүүгийн тайланд залруулсан байна.
- *Баяндун сумын Сум хөгжүүлэх сан:* Зээлийн хүүгийн авлагыг бүртгэхдээ зээл төлөгдөх бүх хугацаагаар урьдчилан тооцож тухайн тайланд жилийн авлагаар бүртгэснийг санхүүгийн тайланд залруулж, авлагыг 2,558.5 мянган төгрөгөөр бууруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

~~өнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 158,547.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 182,691.6 мянган төгрөг болж, 24,234.6 мянган төгрөгөөр өссөн байна.~~



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дунд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0	0	0	0
Банканд байгаа бэлэн мөнгө	158,547.0	182,691.6	24,234.6	13.3
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	158,547.0	182,691.6	24,234.6	13.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 182,689.2 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 2.4 мянган төгрөг нь арилжааны банкны дансанд байршиж байна.

2.8.2 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 165,141.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 192,252.1 мянган төгрөг болж, 27,110.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0,0	0,0	0,0
Төлбөртэй үйлчилгээний авлага	0,0	0,0	0,0
Татаас, санхүүжилтийн авлага	0,0	0,0	0,0
Зээлийн хүүгийн авлага	0,0	0,0	0,0
Бусад авлага	3,610.4	8,837.3	5,226.9
Зээлийн авлага хүү	161,530.9	183,414.8	21,883.9
Дүн	165,141.3	192,252.1	27,110.8

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 93,489.4 мянган төгрөгийн дараах авлага байгаа нь Сум хөгжлийн сангаас 2011-2014 онд олгосон зээл, зээлийн хүү, алдангийн 93,489.4 төгрөг байна. Эдгээр зээлийг төлүүлэхээр шүүхэд хандсан байна.

Энэ нь сангаас аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зээл олголтод сөрөг үр дагавартай байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 468,438.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 464,105.5 мянган төгрөг болж, 4,333.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	5,954.0	6,050.6	96.6
Эм боох материал	51,161.0	55,407.8	4,246.8
Бэлэн бүтээгдэхүүн	6,861.1	6,861.1	0.0
Бичиг хэргийн материал	69,182.0	70,346.7	1,164.7
Аж ахуйн материал	199,516.8	176,955.1	-22,561.7
Сэлбэг хэрэгсэл	663.2	663.2	0.0



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Түлш шатах тослох материал	4,710.2	3,413.4	-1,296.8
Барилгын засварын материал	1,455.3	1,455.3	0.0
Хүнсний материал	863.2	2,113.5	1,250.3
Бусад хангамж	28,476.1	25,243.0	-3,233.1
Мал амьтад	99,595.8	115,595.8	16,000.0
Дүн	468,438.7	464,105.5	-4,333.2

Бараа материалын үлдэгдэл буурсан нь өмнөх онд нөөцөлсөн аж ахуйн материалыг тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5,150,752.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,618,298.1 мянган төгрөг болж, 467,545.4 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	2,833,755.5	3,136,908.9	303,153.4
Автотээврийн хэрэгсэл	224,004.2	214,584.8	-9,419.4
Машин тоног төхөөрөмж	640,763.5	736,765.3	96,001.8
Тавилга эд хогшил	151,646.1	191,248.2	39,602.1
Зам гүүр	259,228.2	303,931.2	44,703.0
Түүх соёл музейн дурсгал	33,324.3	33,324.3	0.0
зүй	764,639.9	762,489.3	-2,150.6
Бусад үндсэн хөрөнгө	15,000.0	0.0	-15,000.0
Дуусаагүй	13,051.4	22,774.3	9,722.9
Ном	4,700.0	5,632.2	932.2
Программ хангамж	210,639.6	210,639.6	0.0
Бусад биет бус хөрөнгө			
Дүн	5,150,752.7	5,618,298.1	467,545.4

Үндсэн хөрөнгө тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 39,900.1 мянган төгрөг, шилжүүлэн авсан 70,000.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй, хандиваар авсан 505,645.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, шилжүүлсэн 70,000.0 мянган төгрөг, акталсан 78,000.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 4,338.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 13,447.8 мянган төгрөг болж, 9,109.4 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт № 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	1,642.1	602.9	-	0.0
Байгууллагад төлөх өглөг	0.0	10,148.6	10,148.6	0.0
Дансны өглөг /ТӨҮГ/	2,696.3	2,696.3	0.0	100.0
Нийт дүн	4,338.4	13,447.8	9,109.4	32.3



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл дэх 602.9 мянган төгрөг нь ЗДТГ-ын ажилчидтай холбоотой, 10,148.6 мянган төгрөг нь байгууллагад төлөх, 2,696.3 мянган төгрөг нь “Наранбулаг” хөгжил ОНӨААТҮГ-ийн НДШ-ийн өглөг байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,079,545.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,352,685.6 мянган төгрөг болж, 273,1400 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дунд эзлэх хувь
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	2,508,753.1	2,508,753.1	0.0	100.0
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	1,099,743.7	1,372,883.6	273,139.9	80.1
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,471,048.9	1,471,048.9	0,0	100.0
Дүн	5,079,545.7	5,352,685.6	273,139.9	94.9

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт гараагүй болно.

Хуримтлагдсан үр дүн данс нь тайлант оны үр дүнгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баяндун сумын ИТХ-ын 2018 оны орон нутгийн төсөв батлах тухай 12 дугаар тогтоолд зааснаар Орон нутгийн ерөнхий орлогын дансанд тайлант онд 66,300.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 126,747.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 191.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Аж ахуй эрхэлсэн орлого	2,000.0	1,933.0	-67.0	96.7
Суутгагчийн 10	28,000.0	29,146.2	1,146.2	104.1
Галт зэвсгийн албан татвар	5,300.0	3,746.0	-1,554.0	70.7
Улсын тэмдэгтийн хураамж	3,500.0	4,182.4	682.4	119.5
Хог хаягдлын хураамж	0.0	270.0	270.0	0.0
Ойгоос ашигласан хэрэглээний төлбөр	1,000.0	982.8	-17.2	100.0
Унд ахуйн усны төлбөр	0.0	13,033.9	13,033.9	0.0
Хадгаламжийн хүүний орлого	19,000.0	30,531.1	11,531.1	160.7
Торгуулийн орлого	5,000.0	25,185.5	20,185.5	503.7
Бусад	2,500.0	2,680.5	180.3	107.2
Газрын дуудлага худалдааны орлого	0.0	15,055.8	15,055.8	0.0
Нийт дүн	66,300.0	126,747.0	60,447.0	191.2

Орон нутгийн төсвийн орлого 60,447.0 мянган төгрөгөөр давсан ба дээрх давсан орлогод хамгийн ихээр нөлөөлсөн орлогуудыг дурьдвал” орлогыг нь төлөвлөөгүй газрын



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүүдлага худалдаанаас 15,055.8 мянган төгрөг, хог хаягдлын хураамжаас 270.0 мянган төгрөгийн орлого орж, унд ахуйн уснаас авах төлбөрийн орлого 13,033.9 мянган төгрөг, торгуулийн орлого 20,185.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын **2,248,124.2** мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, **31,134.1** мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, **1,000.0** мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 4,924.4 мянган төгрөг санхүүжилт дутуу санхүүжигдсэн байна. Орон нутгийн төсвөөс 2,248,124.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4,628.3 мянган төгрөгийг дутуу олгож, туслах үйл ажиллагааны орлого 296.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг дутуу олгосон нь гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна. Туслах үйл ажиллагааны орлого тасарсан нь ЗДТГ-ын туслах үйл ажиллагааны орлого тасарснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,220,058.8** мянган төгрөг буюу 97.6 хувьтай байна.

Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ОНХС-гийн санхүүжилтийг дутуу олгосноос шалтгаалсан байна.

Үүнд:

Хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээнд 251,776.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 234,276.2 мянган төгрөгийн санхүүжилтийг захиалагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Төвлөрүүлэн захирагчийн нэгтгэл дэх байгууллагууд нь Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 9,607.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 75,113.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,194.4 мянган төгрөг, нийт 90,915.1 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс урамшууллын зардалд 6,383.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5,710.8 мянган төгрөг, норматив зардалд 2,460.8 мянган төгрөг, томилолтын зардалд 9,823.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгэх зардалд 5,420.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 61,116.5 мянган төгрөг нийт 90,915.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэлгүй орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ ДАРААХ АСУУДАЛ БАЙНА.

1. Сумдын Засаг дарга нар Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын заалтад зөрчин сумын Засаг даргын захирамжаар урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна. Иймд дараа жил гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан шалгах шаардлагатай байна.

2. Сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг гэрээнд заасны дагуу бүрэн олгоогүй нь аймгийн ОНХС-гийн шилжүүлгийг дутуу санхүүжүүлснээс шалтгаалсан байна. Энэ асуудлыг Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тусгах саналтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баяндун сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 132 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 15 мэдээллийг байршуулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

ДОА-2020/2/СТА-ТТЗ



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 34.548.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баяндун сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	792 127 041,65	836 490 678,89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	158 547 025,08	182 691 588,82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	158 547 025,08	182 691 588,82
3121	Төгрөг	158 547 025,08	182 691 588,82
31211	Төрийн сангийн харилцах	158 520 653,51	182 689 217,25
31213	Арилжааны банк дахь харилцах	26 371,57	2 371,57
33	АВЛАГА	165 141 315,97	189 693 571,30
33401	Дансны авлага /ТӨҮГ/	110 399,98	110 399,98
335	Бусад авлага	165 030 915,99	189 583 171,32
3351	Байгууллагаас авах авлага		5 226 925,45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	165 030 915,99	184356245,87
35	БАРАА МАТЕРИАЛ	468 438 700,60	464 105 518,77
351	Түүхий эд материал	57 115 010,93	61 458 433,76
35110	Тусгай зориулалттай материал	5 954 005,00	6 050 605,00
35130	Эм боох материал	51 161 005,93	55 407 828,76
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6 861 100,00	6 861 100,00
354	Хангамжийн материал	304 866 781,67	280 190 177,01
35410	Бичиг хэргийн материал	69 181 947,04	70 346 657,04
35420	Аж ахуйн материал	199 516 829,54	176 955 153,68
35430	Сэлбэг хэрэгсэл	663 200,00	663 200,00
35440	Түлш, шатах тослох материал	4 710 230,00	3 413 431,20
35450	Барилгын засварын материал	1 455 260,00	1 455 260,00
35460	Хүнсний материал	863 250,00	2 113 530,00
35470	Бусад хангамжийн материал	28 476 065,09	25 242 945,09
35600	Мал амьтад	99 595 808,00	115 595 808,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4 291 757 006,56	4 527 084 095,72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4 291 757 006,56	4 527 084 095,72
391	Газар		
392	Биет хөрөнгө	4 084 383 656,70	4 321 965 070,92
39201	Барилга, байгууламж, орон сууц	2 833 755 477,96	3 136 908 927,96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(106 562 121,27)	(206 068 220,54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224 004 200,00	214 584 800,00



Баяндун сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39204	Хуримтлагдсан элэгдэл	(73 347 561,59)	(103 221 600,08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	640 763 531,81	736 765 280,81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(374 989 159,73)	(389 839 138,71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	151 646 074,90	191 248 174,90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90 304 955,37)	(101 600 845,52)
39209	Зам, гүүрийн байгууламж	259 228 259,11	303 931 233,11
39210	Хуримтлагдсан элэгдэл	(84 698 427,32)	(99 214 408,40)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	33 324 260,00	33 324 260,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	764 639 914,42	762 489 314,42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(121 127 210,22)	(180 117 056,34)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	15 000 000,00	
39217	Ном	13 051 374,00	22 774 349,31
393	Биет бус хөрөнгө	207 373 349,86	205 119 024,80
39301	Програм хангамж	4 700 000,00	5 632 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3 166 250,14)	(3 952 775,20)
39303	Бусад биет бус хөрөнгө	210 639 600,00	210 639 600,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4 800 000,00)	(7 200 000,00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=III	5 083 884 048,21	5 363 574 774,61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4 338 402,00	13 447 761,89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4 338 402,00	13 447 761,89
413	Өглөг	4 338 402,00	13 447 761,89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1 642 151,00	602 901,00
4136	Бусад өглөг	2 696 251,00	12 844 860,89
41361	Байгууллагад төлөх өглөг	-	10 148 609,89
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	2 696 251,00	2 696 251,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5 079 545 646,21	5 350 127 012,72
51	Засгийн газрын хувь оролцоо	5 079 545 646,21	5 350 127 012,72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 508 753 063,67	2 508 753 063,67
512	Хуримтлагдсан үр дүн	1 099 743 690,88	1 370 325 057,39
51210	Өмнөх үеийн үр дүн	856 558 899,57	1 099 743 690,88
51220	Тайлант үеийн үр дүн	243 184 791,31	270 581 366,51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 471 048 891,66	1 471 048 891,66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5 083 884 048,21	5 363 574 774,61

